

“ТОГТООЛД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 2024 оны 06 дугаар тогтоолыг 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдөр батлан, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6801 дугаарт бүртгүүлж, хэрэгжүүлж ажилласан.

Тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын А/50 тушаалаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан.

1. Баталсан удирдамж, хөтөлбөрийн дагуу шинэчилсэн тогтоолын талаар сургалтыг 04 дүгээр сарын 12-ны өдрөөс 26-ны өдрийн хооронд цахим хэлбэрээр 11, танхимаар 14 удаа зохион байгуулж нийт 3850 эмч, эмнэлгийн мэргэжилтэн оролцуулж ажилласан байна.
2. Мөн Нийслэлийн эрүүл мэндийн газар, Хавдар судлалын үндэсний төв, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Өргөө амаржих газар, Амгалан амаржих газар, Хүрээ амаржих газар зэрэг байгууллагуудад ажлын байран дээр очиж мэргэжил арга зүйн сургалтыг хийж, тогтоол хэрэгжүүлэх явцад тулгарч буй асуудлыг сонсож хамтран ажилласан.
3. Шинэчилсэн тогтоолд хорт хавдрын химийн бай эмчилгээний оношийн хамааралтай бүлэгт оруулсан өөрчлөлтийн талаар Хавдар судлалын үндэсний төв болон хорт хавдрын химийн бай эмчилгээ эрүүл мэндийн байгууллагуудын төлөөлөл, хорт хавдрыг даван туулагчдын төлөөлөл болох “Наран ижий заяа” төрийн бус байгууллага, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газруудтай хамтарсан уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, талуудын санал, хүсэлтийг сонсож ажилласан.
4. Шинэчилсэн тогтоолд тусгасан өөрчлөлтийн талаар хэвлэл мэдээллийн байгууллага, нийгмийн сүлжээгээр дамжуулан иргэн, даатгуулагч нарт мэдээллийг хүргэх ажлыг тасралтгүй зохион байгуулж ажиллаж байна.

Дээрх сургалт, уулзалт, хэлэлцүүлгийн мөрөөр эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд, эмч, эмнэлгийн мэргэжилтэн болон иргэн, даатгуулагч нарт шинэчилсэн тогтоолын талаар нэгдсэн ойлголтод хүрэхийн зэрэгцээ тогтоолд тусгагдсан техникийн алдаа болон салаа утга бүхий зарим заалтыг найруулах, зарим орхигдсон өвчний онош, үйлдлийн кодыг нэмэж, хасаж тохируулах, мөн тогтоол шинэчлэх үед бүртгэлгүй байсан бай эмчилгээний эм тогтоол батлагдах үед бүртгэлтэй болсон байх гэх мэт шалтгааны улмаас энэхүү тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолд оруулах нэмэлт өөрчлөлтийг дараах байдлаар боловсруулсан. Үүнд:

Нэг: Тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсалт, төлбөрийн хэмжээ”-ний хэсэгт дараах өөрчлөлтийг хийсэн:

- Хоргүй хавдрын орхигдсон онош, үйлдлийн кодыг жагсаалтын 328 дугаар 51164302 код бүхий оношийн хамааралтай бүлэг (D13, D18 олон улсын өвчний код, 42.3, 43.4, 50.2, 50.3 олон улсын үйлдлийн код)-т нэмэхээр;
- Жагсаалтын 553 дугаар 51240011 код бүхий Эрчимт эмчилгээний А оношийн хамааралтай бүлэгт байх ёстой 96.71, 01.10 олон улсын үйлдлийн кодыг жагсаалтын 554 дугаар 51240012 код бүхий Эрчим эмчилгээний В оношийн хамааралтай бүлэгт андуурч оруулсаныг залруулахаар;
- Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад онош үгүйсгэх тохиолдууд гардаг тул хамаарах оношийн хамааралтай бүлэгт Z03 олон улсын өвчний өвчний кодыг нэмэх;

Хоёр: Тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээний нэгж тохиолдлыг тооцох, санхүүжүүлэх журам”-ын хэсэгт:

- 1 Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт”-ийн жишиг төлбөрийн хэмжээгээр оношилгоо, шинжилгээний өртөгийг тооцоолсон ба лабораторийн урвалж, оношлуурын зардал жил бүр нэмэгдэж байгаатай уялдуулах саналыг ЭМБ-уудаас сургалтын үеэр тавьсан. Иймд удирдамжийн амбулаторийн цогц тусламжийг санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт хэсэгт “Амбулаторийн цогц тусламж үйлчилгээний төлбөрийн хэмжээг Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт”-ийн жишиг төлбөрийн хэмжээгээр тооцоолох бөгөөд тус тушаалын төлбөрийн хэмжээнд өөрчлөлт орсон тохиолдолд оношийн хамааралтай бүлгийн төлбөрийн хэмжээгээр нэмэгдүүлэн тооцох бөгөөд хэрэв тухайн жилд төлбөрийн хэмжээ өөрчлөгдөөгүй тохиолдолд инфляцийн түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэн тооцоолж болно.” гэсэн заалтыг нэмэхээр;
2. Мөн амбулаторийн цогц тусламж, үйлчилгээнд гаргасан зардлын гүйцэтгэлд үнэлгээ хийхэд тогтоолд заасан доод босгыг хангахгүй байгаа тул үе шаттайгаар хэрэгжүүлэх тохируулга хийхээр журамласан. Тухайлбал удирдамжийн амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний 1.2.1-т “71” гэснийг 50, 1.2.2, 1.2.3, 1.2.4- т 70 гэснийг 50 болгон бууруулж өөрчлөхөөр;
3. Мэс заслын тусламж, үйлчилгээний өвөрмөц онцлог байдалтай уялдуулж, үйлчлүүлэгчид ээлтэй тусламж, үйлчилгээг дэмжиж, амбулаториор хийгдэх оношилгоо, ажилбарын бусад зохицуулалтын 4-ийн “Г” заалтаас “мэс заслын тусламж, үйлчилгээ” гэснийг хасахаар;
4. Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний багцыг хэрэгжүүлэх явцад үндэсний лавлагаа төвүүдэд хийгддэг стратегийн хувьд ач холбогдолтой зарим өнчин шинжилгээнүүд, мөн өртөг зардлын хувьд хэт өндөр, даатгуулагч нарт

давтамжтай хийгддэг оношилгоо, шинжилгээнүүдийг өндөр өртөгт оношилгоо, шинжилгээгээр санхүүжүүлэх хэрэгцээ үүссэн. Иймд амбулаториор хийгдэх оношилгоо, ажилбарын бусад зохицуулалтад Монгол Улсад хийгддэг, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар 45,000 төгрөгөөс дээш төлбөрийн хэмжээтэй хүртээмж бага шинжилгээнүүдийг ЭМДЕГ-ын даргын тушаалаар батлан санхүүжүүлэх ба шинжилгээг бусад тусламж, үйлчилгээтэй давхардуулан санхүүжүүлэхгүй байх, үүнтэй уялдуулаад жагсаалтын 593 дугаарт буй 51300047 код бүхий оношийн хамааралтай бүлгийн нэршил хэсэгт “Зарим өндөр өртөгт оношилгоо, шинжилгээ,” гэж нэмэхээр;

5. Техникийн түвшний дараах алдааг залруулах:

- Удирдамжийн эрчимт эмчилгээний 4 дэх заалтын хүснэгтийн 7 дахь мөр хэсэгт байгаа “зохиомол амьсгал г.м “ гэснийг хасах;
- Журмын эрүүл мэндийн байгууллагын хүлээх үүргийн 7.1.1 дахь заалтад 4.5.1 гэснийг 4.6.1, 4.5.2 гэснийг 4.6.2, 7.1.2, 7.1.3 дахь заалтад 4.5.3 гэснийг 4.6.2 гэж өөрчлөх;
- Журмын 5.2 дахь заалтын 51300044 гэснийг 51300046 болгож өөрчлөх

Гурав: Тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Төрөөс төлбөрийг нь хариуцах эмийн зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх журам”-ын хэсэгт:

1. Иргэн, даатгуулагч, ЭМБ-уудад салаа утгыг илтгэж буй заалт болох журмын 2.6 дугаар заалтыг бүхэлд нь хасах, үүнтэй уялдуулан журмын 2.7 дахь заалтыг “Хорт хавдрын дараах химийн бай эмчилгээнд шаардагдах эм, тариаг тухайн тусламж, үйлчилгээг цогцоор үзүүлж буй эмнэлгүүдэд багцаар нь олгож хяналт тавьж санхүүжүүлнэ.” гэж өөрчлөх;
2. Төр хариуцах тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг дэмжих зорилгоор Журмын 5.6. дах заалтыг “Төлбөрийг нь төр хариуцах эм”-ийг санхүүжүүлэхдээ тухайн эмийн нэгдсэн худалдан авалтын үнийг баримтлах бөгөөд нэгдсэн худалдан авалтын үнийн дүн дээр урамшуулалын мөнгөн дүн нэмэгдүүлж санхүүжүүлэх ба хэрэв тухайн эм нь нэгдсэн худалдан авалтад багтаагүй тохиолдолд эрүүл мэндийн даатгалын байгууллага нь нэгжийн үнийг зах зээлийн үнэд суурилан тогтооно.” гэж өөрчлөн найруулах;
3. Журмын “5.10. хэсэгт шинээр заалт нэмэж оруулах. Тухайлбал жагсаалтад *тэмдэглээ бүхий тусгайлан оруулсан дархлаа эмчилгээний эмийн багцыг олон улсын гэрээ хэлэлцээрт заасан эрүүл мэндийн байгууллага болон төлбөрийн хэмжээг баримтлан санхүүжүүлэх бөгөөд хөтөлбөр болон гэрээ дуусах үед санхүүжүүлтийг зогсоох бөгөөд төсөвт тусгасан тохиолдолд санхүүжүүлнэ.” гэж нэмж тусгах;

Дөрөв: Тогтоолын тавдугаар хавсралтаар баталсан “Төрөөс төлбөрийг нь хариуцах зарим өвчин эмгэг, түүний эмийн жагсаалт, хэлбэр, тун” хэсэгт;

1. Жагсаалтын 75 дугаар бүхий Иринотекан, 87 дугаар бүхий Этопозид эм нь хорт хавдрын системийн химийн эм тул хасахаар;
2. Мөн Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/211 тушаалаар өнчин эмийн жагсаалтад орсон хорт хавдрын бай эмчилгээний эм болох Сорафениб

шахмал 200мг, Монгол Улсын эмийн бүртгэлд шинээр бүртгэгдсэн Палбоциклиб бүрхүүлтэй шахмал 75мг, 100мг, 125 мг эмийг Хорт хавдрын бай эмчилгээний эм ангилалд нэмэх, Сүрьеэ өвчний эмийн жагсаалтад Пиразинамид, шахмал 150мг, 400мг болон “эдгээр эмийн хослол” гэж нэмж оруулахаар;

3. Жагсаалтын Цочмог промиелоцитын лейкеми, Архаг лимфолейкеми лимфомууд, Архаг миелопролифератив эмгэгүүд өвчний ангилал дахь 94 дугаар бүхий Нилотиниб, 97 дугаар бүхий Ритуксимаб, 98 дугаар бүхий Руксолитиниб эм, Эрхтэн шилжүүлэн суулгасны дараах байдал ангилал дахь 114 дугаар бүхий Эверолимус шахмал 5мг, 10мг, 2,5 мг эмийг Хорт хавдрын бай эмчилгээний эмийн ангилалруу шилжүүлэхээр тус тус тусгаж ажиллалаа.

Иймд тогтоолийн төслийг боловсруулан Захиргааны ерөнхий хуулийн 62.1-т заасны дагуу санал авахаар байршуулж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР